



БАГЦ ЦАГ ДҮЙЦҮҮЛЭН ТООЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Сайдын 2003 оны 150 дугаар тушаалын хавсралт “Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадварыг дүгнэхэд баримтлах журам”, дээрх журамтай холбоотой Дээд боловсролын тухай хуулийн 2016 оны 04 сарын 14-ний өдрийн 9-р заалтанд оруулсан нэмэлт өөрчлөлтийг үндэслэв.
- 1.2. Энэхүү журмыг Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуульд хэрэгжүүлж буй төгсөлтийн өмнөх сургалтын хөтөлбөрийн хүрээнд оюутан, суралцагчдыг үргэлжлүүлэн ба шилжин суралцуулахад баримтална.
- 1.3. АШУҮИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын газар, холбогдох тэнхимүүд багц цагийг дүйцүүлэн тооцно.

Хоёр. Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт

- 2.1. Гадаад, дотоодын ижил мэргэжлийн сургуулиас шилжин суралцах тохиолдолд:
 1. Суурь боловсролын гэрчилгээ (эх хувь)
 2. Хувийн хэрэг (эх хувь)
 3. ЭЕШ-ийн батламж (эх хувь)
 4. Элссэн сургуулийн томилолт
 5. Элссэн сургуулийн тодорхойлолт
 6. Баталгаажуулсан дүнгийн хуулбар
- 2.2. АШУҮИС ба гадаад, дотоодын бусад их, дээд сургууль төгссөн тохиолдолд:
 1. Дүнгийн хавсралт дипломын хамт (эх хувь)
- 2.3. Гэрээний дагуу, солилцооны хөтөлбөрт хамрагдсан тохиолдолд:
 1. Бүрэлдэхүүн ба салбар сургууль, гадаад харилцааны нэгжийн тодорхойлолт
 2. Суралцсан хугацааны хөтөлбөрийн мэдээлэл, үнэлгээ
- 2.4. Суралцах эрх нь түдгэлзсэн, сургалтаас чөлөөлөгдсөн оюутнууд эргэн суралцаж буй тохиолдолд:
 1. Оюутны албаны албан бичиг (Их сургуулийн захирлын тушаалын дугаар бүхий)

Гурав. Багц цагийг дүйцүүлэн тооцох

- 3.1. Гадаад, дотоодын магадлан итгэмжлэгдсэн их дээд сургууль төгссөн, шилжин суралцаж буй суралцагчид хичээлийн багц цагийг дүйцүүлэн тооцуулах боломжтой.
- 3.2. АШУҮИС -ийн суралцагчийн өмнө судалсан хичээлүүдийн багц цагийг (үнэлгээг зөвхөн ИСУМС-ээс) шууд дүйцүүлэн тооцно.



- 3.3. Гадаадын их, дээд сургуультай байгуулсан хамтын ажиллагааны гэрээгээр суралцсан суралцагчдын хичээлийн багц цагийг шууд дүйцүүлэн тооцно.
- 3.4. Суралцах эрх нь түдгэлзсэн, сургалтаас чөлөө авсан оюутнууд эргэн суралцахад хөтөлбөрийн өөрчлөлттэй холбоотой зөрүү үүссэн тохиолдолд ерөнхий суурь хичээлүүдийг үргэлжлүүлэн тооцох боломжтой ба тухайн хугацааны сургалтын төлбөрөө бүрэн төлсөн байна.
- 3.5. Суралцагч нь дүйцүүлэн тооцуулж буй нийт багц цагийн 20 хувьтай тэнцэх төлбөрийг АШУҮИС-ийн төв дансанд тушаана. Энэ заалт 3.1. –т хамаарна.
- 3.6. Хичээлийн багц цагийг дүйцүүлэхдээ:
 - 3.6.1. Оюутны албанд тус журмын 2 дугаар зүйлд заагдсан баримт бичгүүдийг бүрдүүлж өгнө;
 - 3.6.2. Оюутны алба нь албан бичгээр мэргэжлийн чиглэлийг заан, дүнгийн тодорхойлолтын эх хувьтай хамт Төгсөлтийн өмнөх сургалтын албанд хүргүүлнэ;
 - 3.6.3. Төгсөлтийн өмнөх сургалтын алба нь албан бичгийг үндэслэн урьдчилсан дүн тулгалт хийх ба шилжин суралцах тухайн дамжааны зөрүү хичээлүүдийн багц цаг 9-өөс илүүгүй байна;
 - 3.6.4. Шаардлагатай тохиолдолд хичээлийн агуулгыг холбогдох профессорын багаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ;
 - 3.6.5. Дүнгийн тодорхойлолтод тухайн хичээлийг “тооцов” гэж үнэлсэн үнэлгээг “70%” “С” гэж тооцуулж болно. Суралцагч өөрийн хүсэлтээр дүнгээ ахиулах шалгалт өгч болох ба “АШУҮИС-ийн Суралцагчийг үнэлэх журам” -ын 5.4 заалтын дагуу төлбөр төлнө;
 - 3.6.6. Багц цагийг дүйцүүлэн тооцох хуудсыг үндэслэн дүнг бүрэлдэхүүн сургуулийн арга зүйч нь ИСУМС-д оруулна.
 - 3.6.7. Багц цагийг дүйцүүлэх эсэхийг хавсралт 1 – ийн дагуу хичээл тус бүрээр гарган, Төгсөлтийн өмнөх сургалтын албаны даргаар баталгаажуулна.
 - 3.6.8. Багц цагийг дүйцүүлэн тооцох боломжгүй тохиолдолд хичээлийг нөхөн суралцах ба бүрэлдэхүүн сургууль, профессорын баг хамтран зохион байгуулна.
- 3.7. Гадаадын хамтын ажиллагаа бүхий их дээд сургууль, дотоодын магадлан итгэмжилсэн сургуулиас шилжин ирсэн оюутнуудын дүн “тооцов” үнэлгээтэй тохиолдолд “АШУҮИС-ийн суралцагчдыг үнэлэх журам”-ын дагуу явцын үнэлгээг бүрэн суралцсан гэж тооцно.
- 3.8. Шилжиж ирсэн суралцагчдын дүн А, В, С, D буюу процентон дүнгүй зөвхөн үсгэн дүнтэй тохиолдолд харгалзаж үсгэн дүнгийн хамгийн өндөр процентон дүнгээр нь тооцно
- 3.9. АШУҮИС-д суралцсан багц цагийг дүйцүүлсэн тохиолдолд нэмэлт төлбөрийг авахгүйгээр шууд тооцно.



3.10. Дипломын боловсролын түвшинд суралцсан ерөнхий суурь хичээлийг бакалаврын түвшинд тооцох боломжтой. Мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлийг тооцохгүй.



Хавсралт №1

Төгсөлтийн өмнөх сургалтын алба

Багц цагийг дүйцүүлэн тооцох хуудас

Нэр: овогтой он сар өдөр
 сургуулийн мэргэжлийн..... -р дамжаанд тулгав.

№	Хичээлийн нэр	АШУҮИС, Бүрэлдэхүү н сургууль	Шилжиж ирж буй сургууль	Зөрүү багц цаг	Дүнг тооцох эсэх
1					Шалгалт өгөх
2					Дүнг тооцох

Хөтөлбөрийн зөрүү тооцсон:

/Арга зүйч/

Баталгаажуулсан:

/Албаны дарга/